

ХҮНД АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2018-2021)

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

1.1 Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.2.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг (цаашид “хөтөлбөр” гэх) боловсруулсан болно.

1.2 Хүнд үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал

“Хүнд үйлдвэрийн салбар” гэж уул уурхайн олборлох-баяжуулах салбараас гарсан бүтээгдэхүүнээр бусад үйлдвэрийн түүхий эд, бэлдэц, тоног төхөөрөмж, эд анги, машин механизм үйлдвэрлэдэг салбарыг хэлэх ба хүнд үйлдвэрт өнгөт ба хар төмөрлөгийн үйлдвэрүүд, газрын тос, нүүрс боловсруулах үйлдвэрүүд болон химийн зарим үйлдвэрүүд орно.

“Хүнд үйлдвэржүүлэх” гэдэг томъёололд боловсруулах үйлдвэрлэлд шилжих, түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын болон бусад цогц арга хэмжээг хамааруулж ойлгоно.

Монгол Улсын хувьд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр өмнө нь бие даасан бодлого, хөтөлбөр боловсруулагдан батлагдаж, хэрэгжээгүй байна.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хүнд аж үйлдвэрийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа билээ.

Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр бол 2009 онд батлагдсан “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” юм. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2016 онд дуусч, хэрэгжилтийн байдалд ХХААХҮЯ-наас 2017 оны эхний улиралд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байдаг.

Тус хөтөлбөрт үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох талаар нийт 9 хуулийг шинээр боловсруулан батлуулахаар тусгагдсанаас 8 хууль (бирж, зээлийн баталгаа, хөрөнгө оруулалтын сан, даатгалын сан г.м)-ийг батлуулан, нэг хууль боловсруулах шатандаа байгаа гэж үнэлэгджээ. Мөн Хүнсний, Ашигт малтмалын, Инновацийн, Санхүүгийн түрээсийн, Концессийн, Технологи дамжуулах, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, Хөдөлмөрийн тухай зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгагдсанаас 5

хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд НӨАТ, гаалийн татвар, гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх зэрэг олон дагалдах хуулийг тухай бүр батлан хэрэгжүүлсэн байна.

“Хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол улсад олон үйлдвэр шинээр бий болж, үйлдвэрлэлээ өргөтгөж, шинэ техник технологи нэвтрүүлэн, олон хүнийг ажлын байраар хангасан байна” гэж дүгнэсэн боловч тодорхой тоон үзүүлэлт гаргаагүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, хөдөө орон нутагт хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн дагуу хийгдсэн ажил бүрэн тусгагдаагүй, орон нутгийн байгууллагатай харилцан уялдаатай ажиллаж тайлагнах, мэдээлэл, судалгаатай байх талаар дутагдалтай байна гэж дүгнэжээ.

“Үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох чиглэлээр Хөгжлийн банк, Чингис бонд, тусгай сангуудын хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүд хөнгөлөлтэй зээлд хангалттай хамрагдсан боловч ажлын байр нэмэгдсэн, үйлдвэрлэлээ өргөтгөсөн, шинээр ажлын байр бий болсон зэргээр үр дүн нь хязгаарлагдаж байгаагаас зээл тусламжийн хүрээнд нэвтрүүлсэн шинэ техник, технологи, лизингээр авсан шинэ тоног төхөөрөмж, тэдгээрийн ашиглалт, бүтээмж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шалгуур үзүүлэлттэй уялдуулан үнэлэх боломжгүй байна” гэжээ.

“Цахим мэдээллийн сан, аутсорсинг, технологи дамжуулах төв, инкубаци, үйлдвэр технологийн парк, кластер зэрэг асуудалтай холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байна” гэж үзсэн байна.

Эцэст нь “Хөтөлбөрийн хүрээнд маш олон ажил хийгдсэн боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал нь бүтцийн өөрчлөлтөөр байнга солигдож хийсэн ажил үнэгүйдэх, мэдээлэл нь олдохгүй байх зэргээс шалтгаалан тайланд бүрэн тусгагдаагүйгээс хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн түвшинд хүрээгүй болно” гэж дүгнэсэн.

Манай улсын нийт үйлдвэрлэлийн дийлэнх нь уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан, хялбар технологид суурилсан бөгөөд экспортын бүтээгдэхүүний 81.9%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн, үүнээс 97%-ийг технологийн багтаамжгүй болон нам технологит бүтээгдэхүүн эзэлж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш хүнд үйлдвэрийн салбарт өнгөт төмөрлөгийн чиглэлээр “Эрдмин”, “Ачит ихт” ХХК-иуд “Эрдэнэт үйлдвэр”-ийн балансын бус хүдрийн овоолгыг уусгах-хандлах-электролизлэх технологиор катодын зэс үйлдвэрлэн экспортлож байгаагаас “Эрдмин” үйлдвэр катодын зэсээр төрөл бүрийн цахилгааны утас, кабель, монтажны утас, уртасгагч залгуур зэргийг үйлдвэрлэж байгаа ч Хятад болон ОХУ-ын импортын ижил төрлийн бараа, бүтээгдэхүүнээс дээгүүр үнэтэй байгаагаас борлуулалт хангалтгүй болж, үйлдвэрлэлээ хумьж катодын зэсээ экспортлож байна. Мөн зэс бүтээгдэхүүний импортын татвар хөрш Хятад болон бусад улсуудад өндөр (27-35 %) байгаагаас экспортлох боломжгүй болгож байна.

Хар төмөрлөгийн чиглэлээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ээс гадна “Дархан ГеоМаш”, “Металл индустрал”, “Ораметалл”, “Бэрэн металл”, “Дөл түшиг”, “Жараахайн булаг” зэрэг

хувийн хэвшлийн компаниуд байгуулагдан хаягдал төмөр боловсруулж, уул уурхайн тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэг хэрэгсэл, тээрмийн ган бөмбөлөг, барилгын ган туйван зэрэг цөөн нэр төрлийн боловч манайд эрэлт хэрэгцээ ихтэй ган бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлж байгаа боловч түүхий эдийн хомсдол, ялангуяа хаягдал төмрийн нөөц хангалтгүйгээс үйлдвэрүүд хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй, мөн бүтээгдэхүүний чанарын стандарт хангахгүй зэргээс борлуулалт муудаж, төдийлөн ашигтай ажиллахгүй байна.

Мөн үндсэн үйлдвэрийхээ дотоод хэрэгцээг хангах зориулалтаар 1990 оноос өмнө байгуулагдсан “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр” (хуучин нэрээр)-ийн Засвар механикийн завод, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн харьяа “Төмөр замын засварын завод” зэрэг үйлдвэр, заводууд ажиллаж байгаа ба уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад захиалгын дагуу төрөл бүрийн тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлэх боломжтой ч захиалга төдийлөн сайнгүй байна.

Үүнээс гадна хүнд үйлдвэрийн салбарт хамааруулж болох цементийн үйлдвэрийн хувьд манай улсын барилгын салбарын өсөлт, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, үнийн “супер цикл”-ын үе (2011-2014 он)-д төрийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтгүйн (мөн компаниудын өөрсдийн зах зээл, эрсдлийн судалгаа муу байсан) улмаас тус бүр 1.0 сая.тн/жил хүчин чадалтай цементийн 4 үйлдвэр байгуулагдан, мөн бусад үйлдвэрийн нийлбэрээр нийт хүчин чадал 5.2 сая.тн/жилд хүрсэн нь 1.0 орчим сая.тн/жил цементийн хэрэглээтэй (барилгын салбарын өсөлтийн үед 1.8 сая.тн/жил хүрч байсан) манай улсын хувьд хөрш улсуудад экспортлох боломжгүй нөхцөлд бүтээгдэхүүний илүүдэл үүсч, борлуулалт байхгүйгээс компаниудад эрсдэл үүсэх нөхцөл байдал бий болсон.

Түүнчлэн авто угсралтын үйлдвэрлэлийн салбарт “Экологбус” ХХК, “Цахилгаан тээвэр” ХХК нь автомашины эд анги, нарны зайн хураагуур үйлдвэрлэн экспортод гаргаж байгаа “Моншибасаки” ХХК, “Санко соолар” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд тус салбарт үйл ажиллагаа явуулж байна.

2016 оны 12 сард УУХҮЯ-наас зохион байгуулсан хүнд үйлдвэрийн тооллогоор тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 67 үйлдвэр (аж ахуйн нэгж) бүртгэгдсэнээс 8 үйлдвэрийн үйл ажиллагаа түр зогсолттой байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа гангийн үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 180,0 гаруй мян.тн боловч хүчин чадлын ашиглалт 30-60%- тай байгаа нь түүхий эдийн хязгаарлагдмал нөөц, техник технологийн түвшний харилцан адилгүй байдал, мэргэжлийн инженер техникийн ажилтны хүрэлцээгүйгээс шалтгаалж байна.

Аливаа улсын хөгжлийн суурь болсон хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан ба Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд заасан зорилт, арга хэмжээнүүдэд тулгуурласан.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Уламжлалт салбарын үйлдвэрүүдийг өргөтгөн сайжруулах, том төслүүдийг хэрэгжүүлэх замаар аж үйлдвэрийн шинэ цэгүүдийг бий болгон кластераар хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан дэвшилтэт технологи бүхий хүнд үйлдвэрийг хөгжүүлэн, олон улсын чанарын шаардлагыг хангасан өрсөлдөх чадвар бүхий экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүнээр эхний ээлжинд дотоодын хэрэгцээг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэх

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 2. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэр байгуулж эхлэх, ашиглалтад оруулах

Зорилт 3. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, одоо байгаа үйлдвэрүүдийг суурилагдсан хүчин чадалд хүргэх

Зорилт 4. Нүүрс гүн боловсруулах, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 5. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дагалдах үйлдвэрүүдийн хамт байгуулах

Зорилт 6. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжих, кластераар хөгжих нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 7 Салбарын үйлдвэрүүдийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 8. Салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах

Зорилт 9. Санхүү, хөрөнгө оруулалт, зээл, татварын таатай нөхцөлийг бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

4.1 Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн зорилтыг хангах арга хэмжээ

5.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.1.1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 257 мян.тн/жил катодын зэс, 5800 тн/жил алт, 5.7 тн/жил мөнгө үйлдвэрлэх “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” байгуулах бэлтгэл ажлыг хангаж, төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2019 онд эхлүүлнэ.

5.1.2. Дорнод аймагт зүүн бүсийн холимог металлын орд /баяжуулах үйлдвэр/-уудад түшиглэн цайр, хар тугалганы үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ. (2018-2019 он)

5.1.3. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулна. (2018 он)

5.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.2.1. Төвийн бүсэд Дархан Уул аймагт “Дарханы-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн хүрээнд 600.0 мян.тн/жил хүчин чадалтай шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах, одоо байгаа гангийн үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулах, шинэ гангийн үйлдвэр нэмж байгуулах замаар 470.0 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолборын 1 дүгээр үе шатны бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. (2018-2021)

5.2.2. Төвийн бүсэд “Бэрэн групп”-ын Орхон аймагт хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр” төслийн хүрээнд 100.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, 200.0 мян.тн/жил ган цувимал бүтээгдэхүүний үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулна.

5.2.3. Зүүн бүсэд Дорноговь аймгийн Айраг суманд “МДМУ” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Ширэм болон цутгуурын үйлдвэрийн төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажил 2017 онд эхэлсэн ба 2018 онд 10.0 мян.тн/жил хүчин чадалтай гангийн үйлдвэр, 200.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, гангийн үйлдвэрийг өргөтгөж 50.0 мян.тн/жилд хүргэснээр үйлдвэр бүрэн хүчин чадлаараа 2019 онд ажиллаж эхэлнэ. (2017-2019)

5.2.4. Зүүн бүсэд Дорнод аймгийн Матад сумын нутагт хэрэгжүүлэх “Дорнын хүдэр” ХХК-ийн “Дорнын ган” төсөл нь уурхай-баяжуулах үйлдвэр-ширэмний үйлдвэр-цутгуур/ган/-ын үйлдвэр схемээр 100.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний, мөн 100.0 мян.тн/жил хүчин чадал бүхий цутгуурын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн ба төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2018 онд эхлүүлнэ. (2018-2021)

5.2.5. Төвийн бүсэд Орхон аймагт “Ора металл” ХХК-ийн одоо байгаа 3.0 мян.тн/жил хүчин чадалтай цутгуурын үйлдвэрийн шугамыг бүрэн шинэчилж, 10.0 мян.тн/жил хүчин чадалтай бүрэн автомат шугамаар шинэчилнэ. (2018-2020)

5.2.6. Зүүн бүсэд Дорнод аймгийн Чойбалсан хотод “Жараахайн булаг” ХХК-ийн цутгуурын үйлдвэрийг суурилагдсан хүчин чадалд хүргэж, техник-технологийн шинэчлэл хийнэ. (2018-2020)

5.2.7. Төвийн бүсэд төмөрлөгийн үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах зорилгоор феррохайлшийн үйлдвэрийг байгуулна. (2018-2019)

5.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.3.1. “Эрдэнэт үйлдвэр”-ийн “Засвар механикийн үйлдвэр”-ийн хүчин чадлыг өргөтгөх, техник, технолийг шинэчлэж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах замаар уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн импортоор авдаг эд анги, сэлбэг материал, цахилгаан хэрэгсэл, резинэн эдлэлийн үйлдвэрлэлийг дотоодоос хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. (2018-2020)

5.3.2. Монголд машин үйлдвэрлэлийн суурь бааз бий болгох зорилгоор “Экологбус” ХХК-ны хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд жижиг, дунд, том оворын зорчигч тээврийн автобус угсрах,цахилгаан машин угсрах үйлдвэрийг байгуулна. (2018-2020)

5.3.3. Төвийн бүсэд машин үйлдвэрлэлийн цогцолбор, кластерийн системээр ажиллах жижиг, дунд үйлдвэрүүдийг төвлөрүүлэн байгуулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны багтаамж шингэсэн орчин үеийн машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурийг тавина.

5.4. Хөтөлбөрийн 4 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.4.1. Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт байрлах Багануурын нүүрсний уурхайг түшиглүүлэн 725.0 сая.м3/жил хүчин чадалтай нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийг Улаанбаатар хот хүртэл 160 км урт дамжуулах, түгээх хоолойн хамт байгуулна. Бүтээн байгуулалтын ажлыг 2018 онд эхлүүлж, 2022 онд үйлдвэрийг ашиглалтад оруулна. (2018-2022)

5.4.2. Коксжих нүүрсийг боловсруулж металлургийн кокс үйлдвэрлэж, төмөр, зэс хайлуулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор 300 мян.тн/жил хүчин чадалтай 1 үйлдвэрийг төвийн бүсэд (Дархан уул аймагт) байгуулах, мөн 2.0 сая.тн/жил хүчин чадалтай үйлдвэрийг говийн бүс (“Баянговь нутаг” үйлдвэрлэл технологийн парк)-эд байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.5.1. Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт жилд 1.5 сая.тн түүхий тос боловсруулж, 500.0 мян.тн/жил авто бензин, 680.0 мян.тн/жил дизель түлш зэргийг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2018 онд эхлүүлж 2022 онд ашиглалтанд оруулна.

5.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.6.1. Дархан-Уул аймагт “Дархан үйлдвэрлэл, технологийн парк”-ийг байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

5.6.1. Орхон аймагт “Эрдэнэт үйлдвэрлэл, технологийн парк”-ийг байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

5.6.1. Нийслэлийн Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийг байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2018 оноос эхлүүлнэ.

5.6.1. Өмнөговь аймагт “Баянговь үйлдвэрлэл, технологийн парк”-ийг байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2019 оноос эхлүүлнэ.

5.7. Хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.7.1. Мэргэжлийн холбоод, үйлдвэр, төслийн нэгжүүд бусад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүстэй хамтран ажиллаж шинээр баригдах болон одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдэд шаардлагатай мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй

ажиллах хүчний судалгаа гарган (эсвэл мэргэжлийн байгууллагаар судалгааг хийлгэх) холбогдох яамдад захиалга өгч, хүний нөөцийн асуудлыг системтэйгээр шийднэ.

5.8. Хөтөлбөрийн 8 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.8.1. “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-д холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна. (2018)

5.8.2. “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулна. (2018 он)

5.9. Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.9.1. Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх татварын таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнд үйлдвэрийн зарим тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгслэлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулж, батлуулна.

5.9.2. 2016 онд УИХ-аар батлагдсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуулийн үйлдвэрлэлийг дэмжих сан байгуулах тухай заалтыг хэрэгжүүлнэ.

5.9.3. Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх газрын тос боловсруулах, шатдаг занар болон нүүрснээс хий шингэн түлш үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг Засгийн газраар батлуулна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

"Хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр" болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг дараахь хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1. иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө;

6.2. улсын болон орон нутгийн төсөв;

6.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

6.3. банкны зээл;

6.4. гадаадын зээл, тусламж;

6.5. концессын гэрээ;

6.5. бусад эх үүсвэр.

Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Засгийн газрын бусад гишүүний төсвийн багцад жил бүр тусгана.

Долоо. Хүрэх үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр урт хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д хүнд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан 1 дүгээр үе шатны зорилт, заалтууд биелж дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

“Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүнд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр тусгасан зорилт, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд биелж, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх угтвар нөхцөл хангагдан Монгол улсын нийгэм, эдийн засагт дараах нөлөөллүүд бий болно.

Үүнд :

- Хүнд үйлдвэрийн шинэ чиглэл (Зэсийн баяжмал боловсруулах анхны үйлдвэр, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, Газрын тос боловсруулах үйлдвэр, Коксын үйлдвэр г.м.) бий болж уламжлалт салбарын үйлдвэрүүд сэргэн хөгжиж, суурилагдсан хүчин чадалдаа хүрч ажиллан, шинэ төрлийн үйлдвэрүүд байгуулагдах нөхцөл бүрдэнэ.

-Орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч, тэдгээрийг эзэмших үндэсний боловсон хүчин бэлтгэгдэн, дадлагажина.

- Хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх төслүүдэд 2018-2022 онуудад 7.0 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэнэ.

- Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, худалдааны эргэлт сайжирснаар валютын дотогшоо урсгал бий болж ханш бууралтад нөлөөлнө.

- Хүнд үйлдвэрийн салбар сэргэн хөгжиж, шинэ төрлийн үйлдвэрүүд байгуулагдах эхлэл тавигдаж, нөхцөл бүрдэн, зөвхөн үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын үед л гэхэд шууд ба шууд бусаар 10000 орчим ажлын байр бий болж цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусад даатгал, хүн амын орлогын албан татвараар улс, орон нутгийн төсөвт ихээхэн хэмжээний орлого төвлөрөх болно.

Найм. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

8.1. Засгийн газрын 2017 оны 89 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.5 дахь заалтын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, Засгийн газарт танилцуулна.

---oOo---